



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2011 оны 07 сарын 26 өдөр

Дугаар 223

Улаанбаатар хот

Г “Мах” бондыг бүртгэх тухай 7

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 42.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Жаст агро” ХХК-ийн гаргах 12 сарын хугацаатай, жилийн 16.2 хувийн хүүтэй, нэг бүр нь 10,000 /арван мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 3,000,000 /гурван сая/ ширхэг “Мах” бондыг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /С.Тулгаа/, Хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, төвлөрсөн хадгаламжинд бүртгэхийг “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Д.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан “Жаст агро” ХХК-ийн 3,000,000 /гурван сая/ ширхэг бондоос эхний ээлжинд 1,000,000 /нэг сая/ ширхэг бонд худалдахыг зөвшөөрч, үлдсэн 2,000,000 /хоёр сая/ ширхэг бондыг худалдахдаа Хороонд тухай бүр мэдэгдэж зохих зөвшөөрөл авсны үндсэн дээр худалдахыг “Жаст агро” ХХК /Г.Содномдаржаа/-д үүрэг болгосугай.

3. Бонд гаргах тухай үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаасны газраар баталгаажуулан, уг үнэт цаасны танилцуулгад үндэслэн олон нийтэд үнэ төлбөргүйгээр холбогдох мэдээлэл хүргэж ажиллахыг “Жаст агро” ХХК /Г.Содномдаржаа/, “Би Ди Сек” ХК /Д.Даянбилгүүн/-д тус тус үүрэг болгосугай.

4. Бондын арилжааны тайланг хууль, журамд тогтоосон хугацаанд Хороонд ирүүлж, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлж ажиллахыг “Жаст агро” ХХК /Г.Содномдаржаа/-д үүрэг болгосугай.

5. Бондын борлуулалт, үндсэн болон хүүгийн төлөлтөд холбогдох журмын дагуу хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, “ҮЦГТГХТ” ХХК /Д.Гандулам/-д тус тус даалгасугай.

6. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /С.Тулгаа/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-г тус тус даалгасугай.



ДАРГА

Д.БАЯРСАЙХАН